

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ӨСВӨР-ҮЕ ХҮНС ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/251/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас:315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Н.Гантөгс Утас: 315558 Цахим хаяг: gantugsss@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн : Azure хүлэг аудит ХХК-ийн захирал: Г.Мөнхбаяр Утас:70110090 Цахим хаяг:audit@azure.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ӨСВӨР ҮЕ ХҮНС ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Г.МӨНХЗУЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-03-13 № 514
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өсвөр-Үе хүнс ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг, бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Ирээдүйн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад нөлөөлөх эргэлзээ төрүүлж байгаа нөхцөл байдал аудит хийх шалгалтын явцад материаллаг байдлын түвшинд хүрсэн алдаа зөрчил илрээгүй болно.

Баянзүрх, Хан-уул дүүргийн төрийн өмчийн 103 цэцэрлэг, 163 хичээлийн байр болон 14 сургуульд захиалгын дагуу хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, баталгаажсан бараа бүтээгдэхүүнийг нийлүүлж байна

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

1426050429

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд 38.9 сая төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан боловч гүйцэтгэлээр 272.5 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Төрийн аудитын байгууллага нь санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 99.5 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгасан асуудал нь хамрахгүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	86,685,828.47	146,883,979.29
1.1.2	Дансны авлага	14,794,030.00	265,749,731.30
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	25,806,262.90	34,234,724.82
1.1.4	Бусад авлага	-	20,000.00
1.1.6	Бараа материал	143,820,226.17	81,810,270.46
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	5,871,936.00	2,566,436.83
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	276,978,283.54	531,265,142.70
1.2.1	Үндсэн хөрөнгө	355,185,433.94	312,525,640.92
1.2.2	Биет бус хөрөнгө	36,768,120.00	36,768,120.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	391,953,553.94	349,293,760.92
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	668,931,837.48	880,558,903.62
2.1.1.1	Дансны өглөг	-	23,472,365.00
2.1.1.3	Татварын өр	15,477,981.73	18,449,773.27
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	15,477,981.73	41,922,138.27
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	436,287.06	349,029.65
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	436,287.06	349,029.65
2.2	Өр төлбөрийн нийт дүн	15,914,268.79	42,271,167.92
2.3	Эздийн өмч	312,902,196.93	312,902,196.93
2.3.1	төрийн	312,902,196.93	312,902,196.93
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	19,511,524.19	19,511,524.19
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	36,768,120.00	36,768,120.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	283,835,727.57	469,105,894.58
2.3.11	Эздийн өмчийн дүн	653,017,568.69	838,287,735.70
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	668,931,837.48	880,558,903.62

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	12,412,726,380.01	11,842,636,246.52
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	11,112,824,218.27	10,153,197,049.40
3	Нийт ашиг (алдагдал)	1,299,902,161.74	1,689,439,197.12
5	Хүүгийн орлого	462,437.97	1,637,450.00
8	Бусад орлого	8,455,072.30	10,368,797.24
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,086,992,469.67	1,372,240,249.85
12	Бусад зардал	22,971,916.55	23,762,208.05
18	Татвар төлөхийн өмнөх ашиг	198,855,285.79	305,442,986.46
19	Орлогын татварын зардал	22,182,720.24	32,920,519.45
22	Тайлант үеийн цэвэр ашиг	176,672,565.55	272,522,467.01

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	155,762,196.93	21,679,471.32	36,768,120.00	106,232,278.97	320,442,067.22
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	1,685,423.05	1,685,423.05
3	Залруулсан үлдэгдэл	155,762,196.93	21,679,471.32	36,768,120.00	107,917,702.02	322,127,490.27
4	Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	176,672,565.55	176,672,565.55
6	Өмчид гарсан өөрчлөлт	157,140,000.00	-	-	-	157,140,000.00
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	(754,540.00)	(754,540.00)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(2,167,947.13)	-	-	(2,167,947.13)
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	312,902,196.93	19,511,524.19	36,768,120.00	283,835,727.57	653,017,568.69
12	Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	272,522,467.01	272,522,467.01
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	(87,252,300.00)	(87,252,300.00)
17	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	312,902,196.93	19,511,524.19	36,768,120.00	469,105,894.58	838,287,735.70

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	13,647,428,992.03	12,809,456,047.23
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	13,629,403,178.00	12,764,596,009.70
1.1.6	Бусад мөнгөн орлого	18,025,814.03	44,860,037.53
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	13,539,718,750.65	12,667,750,476.41
1.2.1	Ажиллагчдад төлсөн	620,642,407.37	853,821,077.48
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	175,787,319.23	239,100,028.86
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	11,555,403,885.49	10,810,885,033.00
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	84,632,186.19	84,663,444.61
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	41,575,061.00	30,565,200.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	983,940,300.74	582,391,992.23
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	671,760.00	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	77,065,830.63	66,323,700.23
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	107,710,241.38	141,705,570.82
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн	462,437.97	1,637,450.00
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	462,437.97	1,637,450.00
2.2	Мөнгөн зарлагын дүн	87,300,900.00	4,617,800.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	87,300,900.00	4,617,800.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(86,838,462.03)	(2,980,350.00)
3	Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	679,090.00	78,527,070.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	679,090.00	78,527,070.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(679,090.00)	(78,527,070.00)
4	Валютын ханшийн зөрүү	-	-
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	20,192,689.35	60,198,150.82
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	66,493,139.12	86,685,828.47
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	86,685,828.47	146,883,979.29

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 он Гүйцэтгэл	2025 он		Өөрчлөлт	
		Зорилт	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Нийт орлого	12,421,643.9	14,530,287.9	11,854,642.5	2,675,645.4	81.6
Борлуулалтын орлого	12,412,726.4	14,529,787.9	11,842,636.3	2,687,151.7	81.5
Бусад орлого	8,917.5	500.0	12,006.3	(11,506.3)	2,401.3
Нийт зардал	12,222,788.6	14,487,070.5	11,549,199.5	2,937,871.0	79.7
ББӨ	11,112,824.2	12,841,714.3	10,153,197.1	2,688,517.2	79.1
Цалин	685,182.7	1,000,335.9	905,246.5	95,089.4	90.5
Хоол унааны зардал	87,032.7	167,132.0	134,719.6	32,412.4	80.6
Нийгмийн даатгалын шимтгэл	92,676.3	145,933.5	127,112.6	18,820.9	87.1
Шуудан холбоо	4,525.7	5,616.0	3,983.1	1,632.9	70.9
Цахилгаан	13,163.7	20,034.0	16,966.8	3,067.2	84.7
Шатахуун	25,568.5	28,114.5	21,428.3	6,686.2	76.2
Бичиг хэрэг	4,638.4	6,204.0	5,425.1	778.9	87.4
Хөдөлмөр хамгаалал	9,808.0	12,540.0	6,849.0	5,691.0	54.6
Ашиглалтын зардал	5,813.7	6,012.0	5,475.2	536.8	91.1
Хангамжийн материал	16,044.4	15,517.0	11,761.8	3,755.2	75.8
Засварын зардал	19,829.7	19,000.0	10,110.0	8,890.0	53.2
Түрээсийн зардал	41,045.5	42,000.0	38,181.8	3,818.2	90.9
Элэгдлийн зардал	36,964.5	47,085.2	46,857.8	227.4	99.5
Сэлбэг хэрэгсэл	17,083.6	16,480.0	6,364.9	10,115.1	38.6
Сургалтын зардал	1,495.0	12,110.0	920.0	11,190.0	7.6
Албан томилолт	-	15,000.0	-	15,000.0	-
Бусад зардал	25,042.1	30,930.0	25,858.3	5,071.7	83.6
Татвар, даатгал	1,078.1	2,762.1	4,979.6	(2,217.5)	180.3
Үйл ажиллагааны зардал	1,086,992.5	1,592,806.2	1,372,240.3	220,566.0	86.2
Үйл ажиллагааны бус зардал	22,971.9	52,550.0	23,762.2	28,787.8	45.2
Татвар төлөхийн өмнөх ашиг	198,855.3	43,217.4	305,443.0	(262,225.6)	706.8
Татварын зардал	22,182.7	4,321.7	32,920.5	(28,598.8)	761.7
Цэвэр ашиг	176,672.6	38,895.7	272,522.5	(233,626.8)	700.6
Бусад дэлгэрэнгүй орлого	(2,168.0)	-	-	-	-
Нийт дэлгэрэнгүй орлого	174,504.6	38,895.7	272,522.5	(233,626.8)	700.6
Нийт авлага	14,794.0	15,000.0	270,000.0	(255,000.0)	1,800.0
Нийт өглөг	15,979.9	15,000.0	41,922.0	(26,922.0)	279.5
Хөрөнгө худалдан авалт	79,605.8	179,820.0	4,198.0	175,622.0	2.3
Орон тоо	33.0	33.0	31.0	2.0	93.9
Дундаж цалин	-	1,883,000.0	2,440,000.0	(557,000.0)	129.6

Гурав. Аудитын илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитаар нийт 1,000.7 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд, 1,000.7 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 1 зөвлөмж хүргүүлээ.

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Тайлант хугацаанд өвчтэй болон чөлөөтэй байсан ажилтны цалинг илүү тооцож олгосон байна.	1	370.7	1	370.7	-	-	-	-	-	-	-	-	-	-
2	Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 138,890.8 мянган төгрөгийн 48 хөрөнгийн ашиглалтын хугацаа, үлдэх өртгийг шинэчлэн тогтоогоогүй байна..	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
	Дүн	2	370.7	1	370.7	-	-	1	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар 1 зөрчил² илэрснээс 1 төлбөрийн акт тогтоосон.

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хууль								
Байгууллагын хөрөнгөөр спортын тэмцээн зохион байгуулж шагнал, урамшуулал олгосон байна.	1	630.0	1	630.0	-	-	-	-
Дүн	1	630.0	1	630.0	-	-	-	-

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.